

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТЫН "ШИНЭ ИХ ТОЙРУУ" ХУРДНЫ ЗАМ
ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨВ
(УЛААНБААТАР)-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТЕНДЕР
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын
нэр:

Улаанбаатар хотын "Шинэ их тойруу" хурдны зам төслийн
техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв
(Улаанбаатар) боловсруулах үйлчилгээ

Тендер
шалгаруулалтын
дугаар:

ЗТХЯ/20240103134

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2.Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1.Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1.Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1.Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1.Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1.Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2.Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан

байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө

хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14. Тендерийн жишиг маягтууд

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15. Хувилбарт санал

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17. Чадавхын болон туршлагын шаардлага

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших

өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2.Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3.Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4.ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1.Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2.III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3.Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1.Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2.Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.3.Үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.4.Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.5.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө

үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.2.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.3.Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.4.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2.Хуулийн 14.6-д зааснаар дараах тохиолдолд тендерийн баталгааг хуульд заасан хувь, хэмжээгээр улсын орлого болгоно. Үүнд:

24.2.1. ТШЗ-ны 23-т заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;

24.2.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;

24.2.3. Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан Сангийн яаманд гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

24.3.Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.4.Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1.Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2.ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.

30. Арифметик алдааг залруулах

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

31. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

31.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

32. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох

32.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:

32.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;

- 32.1.2. ТШЗ-ны 21.3-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;
 - 32.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
 - 32.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;
 - 32.1.6. ТШЗ-ны 31.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
- 32.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:
- 32.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;
 - 32.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 34-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;
 - 32.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.
- 32.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.
- 32.4. ТШЗ-ны 32.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

33. Тендерийг эрэмбэлэх

- 33.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.

34. Оролцогчийн чадавхыг дахин магадлах

- 34.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.

34.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

34.3 Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 35. Мэдэгдэл хүргүүлэх** 35.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 36. Гүйцэтгэлийн баталгаа** 36.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 36.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 37. Урьдчилгаа төлбөр** 37.1. Гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй.
- 38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах** 38.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 38.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 38.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.
- 38.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.
- 39. Тендер шалгаруулалтын гомдол** 39.1. Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
ТШЗ 1.1	Улаанбаатар хотын "Шинэ их тойруу" хурдны зам төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар) ЗТХЯ/20240103134
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: ЗТХЯ/20240103134
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: "Үгүй"
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ТШЗ 2.1	Батлагдсан төсөвт өртөг: 16,000,000,000 (арван зургаан тэрбум) төгрөг Үүнээс 2024 онд 16,000,000,000 (арван зургаан тэрбум) төгрөгийг санхүүжүүлнэ.
ТШЗ 6.5	Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.
ТШЗ 7.1	Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.
ТШЗ 7.3	Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
ТШЗ 7.4	ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
Б. АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 23 дугаар хороо, Арцатын ам, Нийслэлийн нутгийн захиргааны байр, Б-блок 7 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,

	<p>Утас: 75757810 www.tender.gov.mn Цахим шуудангийн хаяг: info@procurement.mn, Б.Дөлгөөн хаяг Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр болон тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар захиалагчид гаргаж болно. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана. Захиалагч тодруулга авах хүсэлт хүлээн авснаас хойш тодруулгыг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө бичгээр гаргана. Захиалагч тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) дэх тендерийн баримт бичгийн “тодруулга” хэсэгт нийтэлнэ. Ийнхүү нийтэлсэн даруйд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.</p>
ТШЗ 10.1	<p>Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Тийм” Уулзалтыг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 11 цаг 00 минутад Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын хурлын танхимд зохион байгуулна. Тендерт оролцогчид биечлэн ирж оролцож болохоос гадна цахимаар оролцож болно. Цахимаар орох оролцогчдод цахим холбоосыг 24 цагийн өмнө худалдан авах ажиллагааны цахим системд тодруулгаар оруулна.</p>
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	<p>Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг баталгаат орчуулгын төвөөр орчуулуулж тендерт бэлтгэн ирүүлнэ. Орчуулсан материалд олон улсын мэргэжлийн хэллэг, техник хэллэг, стандарт норм, нормативын нэршлийг олон улсад зөвшөөрөгдсөн нэр томъёогоор ирүүлж болно. Монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.</p>
ТШЗ 12.1	<p>Тендерт оролцогч Үнийн саналыг энэ тендерийн баримт бичгийн V бүлэгт заасан маягт 1-ийн мэдээллийг бөглөж, илгээнэ.</p>
ТШЗ 13.2.2	<p>Оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл (гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт);</p>

	<i>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</i>
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 16.1.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана”</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер зарласнаас хойших өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. - Монгол улсын хуулийн этгээдийн хувьд Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”- ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана. <p><i>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан тухайн улсын хууль тогтоомжийн дагуу татвар, төлбөрөө төлсөн болохыг нотлох баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</i></p> <ul style="list-style-type: none"> - Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)–ээр дамжуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлнэ. Анхааруулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ. <p><i>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг эсхүл дээрх баримт бичигтэй дүйцэхүйц баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</i></p> <ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана. <p><i>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</i></p> <p>Тендерт оролцогч нь энэ тендерийн баримт бичгийн V бүлгийн Маягт 11-д заасан ерөнхий нөхцөлийг хангасан талаар мэдэгдлийг үнэн зөв мэдүүлж, ирүүлнэ.</p>
ТШЗ 16.2	<p>Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

	<p>2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;</p> <p>3. Тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.</p>
ТШЗ 16.4	Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.
ТШЗ 17.4	<p>Тендер шалгаруулалтад түншлэлээр оролцож байгаа тохиолдолд түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн Санхүүгийн чадавхын шаардлага (ТШЗ-ны 18.1), Техникийн чадавх болон туршлагын шаардлага (ТШЗ-ны 19.1)-д заасан чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байх шаардлагатай.</p> <p>-Тендерт оролцогчийн дэлгэрэнгүй танилцуулгыг ирүүлнэ.</p>
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: Шаардана.</p> <p>1. Борлуулалтын орлогын хэмжээ: Тендерт оролцогчийн 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд санхүүгийн тайланд тусгагдсан борлуулалтын орлогын нийт хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 50%-иас доошгүй байх шаардлагатай.</p> <p>2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Тендерт оролцогчийн Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ нь Батлагдсан төсөвт өртгийн 50%-иас багагүй байх шаардлагатай.</p> <p>3. Өр төлбөртэй холбогдох шаардлага: Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна. (Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</p>
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <p>1. Борлуулалтын орлогын мэдээллийг тендерт оролцогчийн санхүүгийн тайлангаас шалгах тул сүүлийн 3 жилийн аудитлагдсан санхүүгийн тайланг ирүүлэх шаардлагатай.</p> <p>2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээний нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн нийлбэрээр эсхүл аль нэгээр нь тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2021, 2022, 2023 онуудын санхүүгийн тайланд тусгагдсан түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ; - Тендерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл; - Банк болон бусад санхүүгийн байгууллагаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт (судлан үзэх боломжтой гэх мэт банканд бодитой санхүүгийн үүрэг хүлээлгээгүй тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй) <p>3. Монгол улсын хуулийн этгээд Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн бус” байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.)</p> <p>Гадаадын хуулийн этгээд харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өр төлбөргүй эсэх тодорхойлолт ирүүлнэ.</p>

(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)

Техникийн чадавх болон туршлагын шаардлага:

1. Үйлчилгээ үзүүлэх үндсэн хүний нөөц: Шаардана.

№	Албан тушаал	Хүний тоо	Тавигдах шаардлага
1.	Төслийн менежер (Төслийн удирдлага)	1	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> Төслийн гүйцэтгэлийг хянах, дүн шинжилгээ хийх, тайлагнах. Оролцогч талуудын харилцааг зохицуулах, шийдвэр гаргах процессын удирдлага. Төсвийн удирдлага, хугацаа, чанар, аюулгүй байдлыг хангах <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> Төсөл удирдлагын чиглэлээр 15-аас дээш жил ажилласан туршлагатай. Мэргэжлийн сертификат (PMP, Prince2 гэх мэт). Магистр болон түүнээс дээш зэрэгтэй (Инженер, Менежмент).
2.	Техникийн менежер (Technical Manager)	1	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> Техникийн асуудлуудыг шийдвэрлэх, зураг төсөл, стандартуудын дагуу ажиллах. Инженерийн багийг удирдах, мэргэжлийн зөвлөмж өгөх. Техникийн тайлан, дүгнэлт, үнэлгээ хийх. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> Инженерийн Магистр буюу түүнээс дээш зэрэг. Замын зураг төсөл, барилга, авто замын чиглэлээр 15-аас дээш жил ажилласан туршлагатай. Техникийн стандарт, дүрмийг сайн мэддэг.
3.	Барилгын инженер (Construction Engineer)	2	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> Барилгын ажлын чанар, стандарт, аюулгүй байдлыг хангах, зураг төсөл, гүйцэтгэлийг хянах. Барилгын гүйцэтгэгчидтэй харилцах, хяналт тавих. Ажлын явцын тайлан гаргах. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> Барилгын инженерийн бакалавр, барилгын зураг төсөл, барилгын чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. Чанарын стандартуудыг мэддэг. Хянах, удирдах ур чадвартай.

ТШЗ 19.1

	4. Замын инженер (Road Engineer)	2.	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Авто зам, замын байгууламж, явган хүний зам, дугуйн замын зураг төсөл, гүйцэтгэлийг хянах. • Замын аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх. • Техникийн дүгнэлт, тайлан боловсруулах. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Замын инженерийн бакалавр, замын зураг төсөл, барилгын чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. • Замын аюулгүй байдлын стандарт, чанарын стандарт, нормыг мэддэг.
	5. Гүүр, хиймэл байгууламжийн инженер (Bridge and Structural Engineer)	2	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Гүүр болон хиймэл байгууламжийн зураг төсөл боловсруулах, хянах. • Барилгын ажилд чанар, аюулгүй байдлын шаардлагыг ханган ажиллах. • Гүүр болон хиймэл байгууламжийн ашиглалтын нөхцөл байдал, тогтвортой байдлыг үнэлэх. • Хяналт тавьж, техникийн зөвлөгөө өгөх. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Замын инженерийн бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй. • Гүүр, хиймэл байгууламжийн зураг төсөл, барилгын чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. • Гүүр болон хиймэл байгууламжийн стандарт, дүрэм, техникийн шийдлүүдийн талаар мэдлэгтэй.
	6. Хот төлөвлөгч (Urban Planner)	1	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Төслийн зорилго, төлөвлөгөөг тодорхойлох, стратеги боловсруулах. • Орон нутгийн засаглал, иргэд, хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах, санал солилцох. • Судалгаа, дүн шинжилгээ хийх, статистикийг ашиглан мэдээлэл боловсруулах. • Нийтийн тээвэр, замын хөдөлгөөн, газар ашиглалтын төлөвлөлтөд оролцох. • Төслийн явц, шийдлүүдийн талаар тайлагнах. <p>Шаардлага:</p>

			<ul style="list-style-type: none"> • Хот төлөвлөлт, газар зүй, архитектур, эсвэл холбоотой бусад чиглэлээр Магистр болон түүнээс дээш зэрэгтэй. • Хот төлөвлөлтийн төсөл, дэд төсөл дээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. • Нийтийн тээвэр, замын хөдөлгөөн, газар ашиглалтын төлөвлөлтийн талаар мэдлэгтэй. • CAD, GIS зэрэг загварчлалын программ хангамжийг ашиглах чадвартай.
7.	Инженерийн шугам сүлжээний инженер (Utilities Engineer)	2	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Ус, дулаан, цахилгаан, холбооны шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, хянах. • Инженерийн шугам сүлжээний барилгын ажлын явц, чанарыг хянах, гүйцэтгэлийг удирдах. • Шугам сүлжээний асуудлуудыг шийдвэрлэх, оролцогч талуудтай хамтран ажиллах. • Аюулгүй байдлын стандарт, байгаль орчны шаардлагыг хангах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Инженерийн шугам сүлжээний чиглэлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй. • Ус, дулаан, цахилгаан, холбоо зэрэг инженерийн шугам сүлжээний төлөвлөлт, барилга угсралтын чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. • Холбогдох стандарт, норм, дүрмийг сайн мэддэг.
8.	Геодезийн хэмжилтийн инженер (Survey Engineer)	1	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Газарзүйн хэмжилт, барилгын талбайн хэмжилт хийх. • Зам, гүүр, инженерийн шугам сүлжээний ажлуудад шаардлагатай хэмжилтийн өгөгдөл бэлтгэх. • Барилгын болон дэд бүтцийн зураг төсөл, төлөвлөлтийн нарийвчлалыг хангах. • Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг ашиглах, хэмжилтийн нарийвчлал, өгөгдлийг баталгаажуулах. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Геодези, хэмжилтийн инженерийн бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй.

			<ul style="list-style-type: none"> • Геодези, хэмжилтийн чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. • GPS, хэмжилтийн багаж хэрэгсэлтэй ажиллах туршлагатай.
9	Геотехникийн инженер (Geotechnical Engineer)	1	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Талбайн хөрс, газарзүйн тогтворжилтын үнэлгээ хийх. • Барилга, зам, гүүрний суурийн дизайн, техникийн шийдлийг боловсруулж хянах. • Хөрс, усны нөлөөллийг үнэлж, хөрсний тогтворгүй байдлаас үүдэлтэй эрсдэлийг бууруулах шийдлүүд боловсруулах. • Барилгын суурийн чанар, аюулгүй байдлын стандартын дагуу үнэлгээ хийх. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Геотехникийн инженерийн бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй. • Хөрс, суурь бүтцийн судалгаа, шинжилгээний чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. • Хөрсний механик, суурь бүтцийн дизайн, газарзүйн тогтворжилт, газар хөдлөлтийн аюулгүй байдлын мэдлэгтэй.
10.	Материалын инженер (Materials Engineer)	1	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Төслийн барилгын ажилд ашиглах материалын чанарын шалгалт, шинжилгээ хийх. • Материалын туршилт, лабораторийн шинжилгээний үр дүнг хянах, тайлагнах. • Материалын стандартын шаардлага хангах эсэхийг шалгах, хяналт тавих. • Материалын бат бөх байдал, чанарыг үнэлэх, сайжруулах зөвлөмж өгөх. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Материал судлал эсвэл иргэний инженерийн бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй. • Барилгын материалын шинжилгээ, чанарын хяналтын чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. • Барилгын материалын стандарт, чанарын шалгуур, туршилтын аргуудын талаар мэдлэгтэй.
11.	Техникийн хяналтын	1	Үүрэг:

	инженер (Quality Control Engineer)		<ul style="list-style-type: none"> • Материалын чанарыг хянах, тавигдах шаардлага боловсруулах. • Чанарын стандарт, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхийг шалгах. • Чанарын тайлан гаргах. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Техникийн хяналтын чиглэлээр 5-10 жил ажилласан туршлагатай. • Барилгын чанар, стандартын мэдлэгтэй.
12.	Нийтийн тээврийн инженер (Public Transport Engineer)	1	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Нийтийн тээврийн системийн төлөвлөлт, дизайны асуудлуудыг шийдвэрлэх. • Тээврийн урсгалыг зохицуулах, шугамын зураг төсөл боловсруулах. • Нийтийн тээврийн тайлан, дүгнэлт боловсруулах. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Нийтийн тээврийн инженерийн чиглэлээр 5-10 жил ажилласан туршлагатай. • Нийтийн тээврийн системийн загварчлал, шинжилгээ хийх чадвартай.
13.	Байгаль орчны инженер (Environmental Engineer)	1	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх, хамгаалалтын арга хэмжээг төлөвлөх. • Төслийн явцад байгаль орчны стандарт, дүрмийг хангах. • Байгаль орчны тайлан, дүгнэлт гаргах <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчны инженерийн бакалавр, байгаль орчны менежмент, үнэлгээний чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. • Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх чадвартай.
14.	Гадна тохижилт, ландшафтын инженер (Landscape Architect)	1	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Гадна тохижилтын загвар, дизайн боловсруулах. • Ногоон байгууламжийн төлөвлөлт, зураг төсөл боловсруулах. • Гадна тохижилтын тайлан, дүгнэлт гаргах <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Гадна тохижилт, ландшафтын инженерийн бакалавр, дизайны

			<p>чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай.</p> <ul style="list-style-type: none"> Гадна тохижилтын стандартыг мэддэг.
15.	Санхүүгийн менежер (Financial Manager)	1	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> Төсвийн хяналт, зардлын тооцоолол хийх, тайлагнах. Санхүүгийн тайлан, дүн шинжилгээ хийх. Төсөлд шаардлагатай санхүүгийн зөвлөмж гаргах. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> Санхүүгийн менежментийн чиглэлээр бакалавр, төсөл санхүүжилт, зардлын менежментэд 10-аас дээш жил ажилласан туршлагатай. Төсвийн хяналт, зардлын тооцоолол хийх чадвартай
16.	Төсөвчин (Cost Estimator/Quantity Surveyor)	1	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> Төслийн зардлын тооцоолол хийх, барилгын ажлын төсвийг боловсруулах. Зардлын хяналт, төсөв, төлөвлөгөөг боловсруулах, баталгаажуулах. Төслийн зардлыг үр ашигтай төлөвлөх, шаардлагатай үед зардлын өөрчлөлтийн шинжилгээ хийх. Төсвийн тайлан бэлтгэж, төслийн удирдлагад зөвлөгөө өгөх. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> Санхүү, эдийн засаг эсвэл Авто зам эсвэл барилгын инженерийн чиглэлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй. Барилгын төсөв боловсруулах, төсөв, зардлын хяналт хийх чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. Барилгын зардлын тооцоолол, эдийн засгийн шинжилгээ хийх чадвартай.
17	Олон нийтийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Stakeholder Engagement Specialist)	1	<p>Үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> Оролцогч талуудтай мэдээлэл, харилцаа тогтоох. Төслийн явцын талаар олон нийтэд мэдээлэх, тайлагнах. Иргэдийн санал, хүсэлт, санал шүүмжийг хүлээн авах, боловсруулах. <p>Шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> Хүрээлэн буй орчин, иргэдийн оролцоо, хуулийн болон зохицуулалтын мэдлэгтэй.

	<table border="1"> <tr> <td data-bbox="437 152 517 248"></td> <td data-bbox="517 152 791 248"></td> <td data-bbox="791 152 1495 248"> <ul style="list-style-type: none"> • Коммуникацийн чадвартай, олон нийттэй ажиллах туршлагатай </td> </tr> <tr> <td colspan="2" data-bbox="437 248 791 322">Нийт хүний тоо</td> <td data-bbox="791 248 1495 322">21 хүн</td> </tr> </table>			<ul style="list-style-type: none"> • Коммуникацийн чадвартай, олон нийттэй ажиллах туршлагатай 	Нийт хүний тоо		21 хүн
		<ul style="list-style-type: none"> • Коммуникацийн чадвартай, олон нийттэй ажиллах туршлагатай 					
Нийт хүний тоо		21 хүн					
ТШЗ 19.2	<p>2. Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: “Шаардана”</p> <p>Оролцогч этгээд нь сүүлийн 10 жилийн хугацаанд 3-аас доошгүй удаа ижил төстэй олон түвшний авто зам эсхүл тойрог зам, хурдны замын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулсан зөвлөх үйлчилгээг үзүүлсэн туршлагатай байна.</p> <p>3. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”</p> <p>Тендерт оролцогч Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг энэ тендерийн баримт бичгийн V бүлэгт заасан Маягт 4-ийн дагуу мэдээллийг бөглөж, илгээнэ.</p> <p><i>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</i></p> <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <p>1. Тендерт оролцогч хүний нөөцтэй холбоотой дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тендерт оролцогч хүний нөөцийн талаарх мэдээллийг энэ тендерийн баримт бичгийн V бүлэгт заасан Маягт 7-д заасны дагуу мэдээллийг бөглөж, ирүүлнэ. - Инженер, техникийн ажилтнуудын жагсаалтыг маягтын дагуу гаргаж, тухайн төсөл арга хэмжээнд ажиллуулахаар захирлын тушаалаар томилсон байна. -Санал болгож буй ажилтны жишиг намтар (CV)-ыг V бүлэгт заасан Маягт 8-д заасны дагуу мэдээллийг бөглөж, ирүүлнэ. -Санал болгож буй Инженер, техникийн ажилтнуудын 50 хувиас дээш хувь нь үндсэн ажилтан байна. - Санал болгож буй Монгол улсын иргэн бүхий мэргэжилтэний хувьд сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia) системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. https://bit.ly/3J1QmHZ Хэрэв санал болгож буй ажилтан нь гадаад улсад сургууль төгссөн бол дипломын хуулбарыг орчуулгын хамт ирүүлнэ. <p><i>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд ажиллах хүчний жагсаалтыг ирүүлэхдээ дипломын хуулбар, мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй ажилтны хүчин төгөлдөр мэргэжлийн гэрчилгээг консулын</i></p>						

	<p><i>баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</i></p> <p>2. Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд: Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн маягт 2, 3-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл ирүүлнэ. Мэдээллийг нотлох баримт бичиг ирүүлнэ. Үүнд: - Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар; - Ажил хүлээлцсэн акт Ижил төстэй үйлчилгээнд Олон түвшний, тойрог замын, хурдны авто замын төслийн аль нэгд ТЭЗҮ, зураг төслийн ажилд үндсэн гүйцэтгэгчээр зөвлөх үйлчилгээг үзүүлсэн тооцно. <i>(Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичигтэй дүйцэхүйц баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ.)</i></p>
ТШЗ 19.3	Тусгай зөвшөөрөл түүнтэй дүйцэхүйц тухайн улсдаа авсан эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл: Шаардахгүй.
ТШЗ 20.1	Санал болгож буй үйлчилгээ нь техникийн тодорхойлолт (ажлын даалгавар)-д тавигдсан шаардлагад нийцсэнийг нотолсон албан бичгийг тендерт ирүүлнэ. Үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулгыг Маягт 5-ын дагуу ирүүлэх. Үйлчилгээ үзүүлэх хуваарь Маягт 6-ын дагуу ирүүлэх.
ТШЗ 21.4	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулна”
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: 80,000,000 (наян сая) төгрөг Гадаадын этгээд гадаад улсын банкнаас баталгаа гаргуулах тохиолдолд Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/252 дугаар тушаалын хавсралт “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-ын 4 дэх хэсгийн дагуу гаргаж ирүүлнэ. Монгол улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллага нь журмын 4.3.2-т заасныг хэрэгжүүлэхэд техникийн шийдлээс шалтгаалан цахим системд гадаадын банканд байршуулсан баталгааг дамжуулах боломжгүй тохиолдолд уг баталгааны хувийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлснийг үндэслэн цахим системд бүртгэх боломжтой.
ТШЗ 24.4	Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.3	Тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээд нь тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр www.tender.gov.mn дамжуулан заавал цахимаар илгээнэ. Цахим системээр материал илгээхийн тулд дараах зүйлсийг анхаарна уу. Үүнд: 1. Өөрийн компанийн нэр дээр www.tender.gov.mn системд бүртгэл үүсгэсэн байх шаардлагатай.

	<p>2. Тендерт оролцогч тендерийг цахимаар илгээхдээ тоон гарын үсгээр баталгаажуулна.</p> <p>3. Тоон гарын үсгийг МонПасс СА ХХК (цахим хуудас: www.monpass.mn, холбогдох утас: +976 18002535), Тридум кей ХХК (цахим хуудас: www.tridumkey.mn, холбогдох утас: +976 70120722) гэсэн гэрчилгээ олгогч байгууллагын аль нэгээс нь авна.</p>
ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 22 дугаар зүйлийн 22.6 заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээнэ.</p> <p>Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 10-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ. Бүх материалыг нууцалж ирүүлсэн тохиолдолд татгалзах үндэслэл болно.</p>
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр</p> <p>Цаг: Төрийн Худалдан авах ажиллагааны газрын цахим системийн цагаар 09 цаг 00 минут</p>
ТШЗ 26.2	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр</p> <p>Цаг: Төрийн Худалдан авах ажиллагааны газрын цахим системийн цагаар 09 цаг 30 минут</p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг:</p> <p>Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 23 дугаар хороо, Арцатын ам, Нийслэлийн нутгийн захиргааны байр, Б-блок 7 дугаар давхар,</p>
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.1	<p>Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”</p>
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 36.1	<p>Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Туйм”</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийг дагуу Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.</p>

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

*(Үйлчилгээний даалгавартай тендер шалгаруулалтын
“ТЭЗҮ” хэсгээс танилцана уу)*

**IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

(Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг ашиглахгүй)

V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягт 1.Тендер илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [**“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих**]. [**Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих**].
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [**ажлын 30 ба түүнээс дээш хоногийн тоо**] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:*

Хаяг:

Маягт 2.Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 3.Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 5. Үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврыг гүйцэтгэх аргачлалын талаарх танилцуулга болон хэрэв ажлын даалгаврын талаар гаргах санал, зөвлөмж ирүүлнэ.

Маягт 6. Үйлчилгээ үзүүлэх хуваарь

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврын дагуу үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ. (Гэрээ баталгаажуулах маягт хэсгийн гэрээний “Хавсралт 4”-ийн дагуу боловсруулж ирүүлнэ)

Маягт 7. Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 8. Санал болгож буй ажилтны жишиг намтар (CV)

Санал болгож буй албан тушаал: _____

Овог, нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшин ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Маягт 9.Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]

Маягт 10.Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

Маягт 11. Ерөнхий шаардлагыг хангасан талаарх мэдэгдэл

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай **[оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад тендерийн баримт бичигт заасан Ерөнхий шаардлагыг хангаж байгаагаа дараах байдлаар мэдэгдэж байна.Үүнд:

1. Манай компани, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, хууль ёсны төлөөлөгч, түншлэлийн бусад бүх гишүүд болон туслан гүйцэтгэгчийн аль нь ч дараах нөхцөл байдалд ороогүй болохоо үүгээр баталж байна. Үүнд:

1.1.дампуурсан, татан буулгасан, үйл ажиллагаагаа зогсоосон, шүүхийн шийдвэр гүйцэтгэл явагдаж байгаа, эрх хүлээн авагч томилогдсон, бүтцийн өөрчлөлтөд орсон, эсхүл үүнтэй ижил төстэй нөхцөл байдалд ороогүй болохыг;

1.2.гэмт хэрэг зохион байгуулах, мөнгө угаах, террорист ажиллагаа, хүүхдийн хөдөлмөр болон хүний наймааны хэрэгт оролцсон шалтгаанаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын Холбооноос шүүхийн болон захиргааны эцсийн шийдвэр гарч яллагдсан эсхүл санхүүгийн санкцаар шийтгүүлсэн; эдгээр хасагдах нөхцөлүүд буюу шалгуур үзүүлэлтүүд нь дээр дурдсан ял шийтгэл болон санцгийг хүлээсэн хувь хүн, хуулийн этгээд хувьцааны дийлэнхийг эзэмшдэг буюу удирдан чиглүүлдэг хуулийн этгээдэд мөн хамааралтай;

1.3.сүүлийн таван жилийн хугацаанд ажил гүйцэтгэх гэрээний үүргээ хэсэгчлэн болон бүрэн биелүүлээгүйн улмаас гэрээ хугацаанаасаа өмнө

цуцлагдаж байгаагүй, гэрээ цуцалсантай холбоотой маргаан нь эцэслэн шийдэгдээгүй, бидний гэм буруу бүрэн тогтоогдоогүй байгаагаас бусад;

1.4.үйл ажиллагаа явуулж буй бүртгэлтэй улс, эсхүл төсөл хэрэгжүүлж буй нэгжийн үйл ажиллагаа явуулдаг улсын хууль дүрмийн дагуу татвар шимтгэл төлөхтэй холбоотой үүргээ биелүүлээгүй;

1.5.Дэлхийн Банк болон бусад олон талт хөгжлийн банкны хар жагсаалтад орсон, <http://www.worldbank.org/debarr>-д нийтлэгдсэн бол (хар жагсаалтад байгаа бол тендерийн өргөдөл гаргагч, эсхүл тендерт оролцогч нь энэхүү гэрээний хүрээнд хийх ажилд уг хар жагсаалтад заасан үйл ажиллагаатай холбоогүй болохоо нотлох баримт бичгийг ирүүлэх ба тодорхой урьдчилан сэргийлэх арга хэмжээ авснаа нотлох шаардлагатай); эсхүл аливаа худалдан авах ажиллагаанд оролцохдоо төсөл хэрэгжүүлж буй нэгжээс шаардсан аливаа мэдээллийг ирүүлэхдээ худал мэдэгдэл баталгаа өгсөн гэж буруутгагдсан.

Олон улсын байгууллага (ADB, WB, AIIB, JICA, KfW зэрэг) -аас санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээнд шалгарч гэрээний үүргээ биелүүлээгүй зөрчил гаргаагүй болно.

1.6.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй этгээд.

1.7.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлөөс баталсан эрсдэлийн менежментийн мэдээллийн бүртгэлд бүртгэгдсэн.

2.Тендерийн ажиллагаа болон холбогдох гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан:

2.1. Уг гэрээтэй холбоотой тендер шалгаруулалтын манай компани, түншлэл гишүүн, туслан гүйцэтгэгч нь хууль бус зүйл хийгээгүй, гэрээг гүйцэтгэх явцад хууль бус үйлдэл гаргахгүй;

2.2.Уг гэрээний хүрээнд манай компани, түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч нь НҮБ (Нэгдсэн Үндэстний Байгууллага), Европын Холбооны хоригт байгаа бараа материал, тоног төхөөрөмж худалдан авахгүй, нийлүүлэхгүй, салбарт үйл ажиллагаа явуулахгүй;

3.Энэхүү Гэрээний хүрээнд хамтрах манай туслан гүйцэтгэгчид, томоохон ханган нийлүүлэгчид нь байгаль орчны болон хөдөлмөрийн олон улсын стандартыг баримталж, тухайн улсын хууль дүрэм, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын болон байгаль орчны дүрэм журмыг чанд мөрдөнө. Мөн түүнчлэн бид холбогдох байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө болон адил төстэй баримт бичгүүдэд тусгасан байгаль орчны болон нийгмийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх бөгөөд ямар ч тохиолдолд бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно.

4.Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд бид, мөн түүнчлэн түншлэлийн бүхий л гишүүд болон туслан гүйцэтгэгч нар нь (i) тухай бүр шаардсаны дагуу, тендерийн ажиллагаа болон Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээллийг гарган өгөх, (ii) Захиалагч, эсвэл тэдгээрээс томилогдсон төлөөлөгчид холбогдох данс, тэмдэглэл, баримт бичгүүдийг хянан шалгах, гэнэтийн шалгалт хийх болон ажлын талбайд болон холбогдох төсөлд нэвтрэхийг зөвшөөрөх, тийм боломжоор хангахыг зөвшөөрч байна.

5.Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд, бид, мөн түүнчлэн манай Түншлэлийн бүх хамтрагчид болон Гэрээний Туслан Гүйцэтгэгч нар бүгд дээр дурдсан тэмдэглэл, баримт бичгүүдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хадгалахаа баталж байгаа бөгөөд ямар ч тохиолдолд Гэрээ бүрэн биелэгдэж дууссан эсхүл цуцалснаас хойш хамгийн багадаа зургаан жилийн хугацаанд хадгална. Санхүүгийн гүйлгээ болон тайлангуудыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу аудитад хамруулна. Мөн, бидэнд байгаа Тендер шалгаруулалт, гэрээний үйл ажиллагаатай холбоотой олж авсан, боловсруулсан өгөгдөл мэдээлэл (хувь хүний мэдээлэл үүнд багтана) нь Захиалагчийн мөрддөг хуульд нийцсэн байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,

албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс

томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж үйлчилгээ үзүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. *Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:*

ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;

1. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
2. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
3. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
4. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
5. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
6. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Үйлчилгээ” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
 - 1.1.8. “Ажлын байр” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
 - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.

- 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
- 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
- 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
- 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

- | | | | |
|------------------------|---------|------|---|
| Захиалагчийн үүрэг | нийтлэг | 2.1. | Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө. |
| | | 2.2. | Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө. |
| | | 2.3. | Захиалагч нь үйлчилгээ авахтай холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна. |
| Захиалагчийн төлөөлөгч | | 2.4. | Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно. |
| | | 2.5. | Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана. |
| | | 2.6. | Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно. |
| Талбайд зөвшөөрөл | нэвтрэх | 2.7. | Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно. |
| | | 2.8. | Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна. |

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

- | | | | |
|---------------------|---------|------|--|
| Гүйцэтгэгчийн үүрэг | нийтлэг | 3.1. | Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө. |
| | | 3.2. | Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө. |
| | | 3.3. | Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна. |

- 3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.
- 3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
- 3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.
- Гүйцэтгэгчийн төлөөлөгч 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.
- 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Техникийн болон ажлын талбайн өгөгдөл 3.11. Захиалагч нь үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдлын талаарх өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.
- Аюулгүй байдал 3.12. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
- 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.
- 3.14. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.
- 3.15. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 3.16. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.17. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.18. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

- Ажил эхлэх 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын

- үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
- 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.
- Хугацаа сунгах 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
- 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;
- 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
- 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
- 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.
- 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
- 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
- 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- Ажлын явцын тайлан 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
- 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- Гэрээний үнэ 5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
- 5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- Урьдчилгаа төлбөр 5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.
- 5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.

- Төлбөрийн нөхцөл
- 5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.
 - 5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
 - 5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
 - 5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
 - 5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
 - 5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

- Урьдчилгаа баталгаа төлбөрийн
- 6.1. ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.
- Гүйцэтгэлийн баталгаа
- 6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.
 - 6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:
 - 6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
 - 6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
 - 6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
 - 6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
 - 6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
 - 6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.
- Чанарын баталгаа
- 6.7. Үйлчилгээний чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.
 - 6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.

- 6.9. ГЕН-ийн 6.9-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
- 6.10. Баталгаат хугацаанд үйлчилгээнд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
- 6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.
- 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
- 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- | | | |
|-------------------------|-----------|--|
| Бусдад хохирлыг арилгах | учруулсан | 7.1. Үйлчилгээ үзүүлэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна. |
| | | 7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй. |
| Захиалагчийн эрсдэл | хүлээх | <p>7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>7.3.1. Үйлчилгээний үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;</p> <p>7.3.2. гүйцэтгэсэн үйлчилгээг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;</p> <p>7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас үйлчилгээ, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;</p> <p>7.3.4. Захиалагчийн ажлын даалгаврын алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.</p> |
| | | 7.4. Үйлчилгээний доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй. |
| Даатгал | | 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна. |
| | | 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна. |
| | | 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ. |

- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

- | | | |
|------------------------|-----------|---|
| Доголдлыг арилгах | илрүүлэх, | <ul style="list-style-type: none"> 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн үйлчилгээ, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна. 8.2. Захиалагчийн төлөөлөгч үйлчилгээний явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө. 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ. 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ. 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана. 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно. 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө. 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана. |
| Далд доголдол | | <ul style="list-style-type: none"> 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна. |
| Зураг төслийн доголдол | | <ul style="list-style-type: none"> 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна. 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна. |

ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- | | |
|-------------------------|---|
| Захиалагч гэрээг цуцлах | <ul style="list-style-type: none"> 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно: <ul style="list-style-type: none"> 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үйлчилгээ үзүүлээгүй; 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй; 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн; |
|-------------------------|---|

- 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
 - 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
 - 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
 - 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
 - 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- Гүйцэтгэгч гэрээг цуцлах
- 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
 - 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
 - 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
 - 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
 - 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам
- 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
 - 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
 - 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
 - 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.

- Гэрээг цуцалсны дараах төлбөр
- 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

АРАВ. БУСАД ЗААЛТ

- Мэдэгдэл
- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

- | | |
|---|---|
| Төлөөлөгч өөрчлөгдөх | <p>10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.</p> <p>10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.</p> <p>10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.</p> <p>10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.</p> |
| Үйлчилгээнд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл | <p>10.12. Талууд үйлчилгээний чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.</p> <p>10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.</p> <p>10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.</p> <p>10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.</p> |
| Гэнэтийн давагдашгүй шинжтэй байдал буюу хүчний онцгой нөхцөл | <p>10.16. Үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.</p> |

- Оюуны өмчийн эрх зөрчих 10.20. Үйлчилгээг үзүүлэх явцад болон үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- Алданги 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.
- Маргаан шийдвэрлэх 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 4.1.	Үйлчилгээ үзүүлж эхлэх хугацаа: Гэрээ байгуулагдсан өдрөөс
ГЕН 4.2.	Үйлчилгээ үзүүлэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 4.9.	Үйлчилгээний явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: “Хийхгүй”
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”
ГЕН 5.6.	Төлбөр төлөх хугацаа: [он, сар, өдөр] Төлбөрийг хэсэгчилсэн төлөх бол төлбөр төлөх үе шатны хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 6.1.	Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: [мөнгөн дүн бич] Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 6.7.	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: ["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих.] Чанарын баталгаа шаардах бол, Чанарын баталгааны хэмжээ: [Гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийн хооронд сонго.]
ГЕН 6.13.	Баталгаат хугацаа: [Тендер шалгаруулалтын баримт бичигт үндэслэн баталгаат хугацааг тогтоож бичих]
ГЕН 7.5.	Даатгал: [Ажлын онцлогийг харгалзан гарч болох эрсдэлийг тодорхойлон Гүйцэтгэгчийн даатгуулах даатгалуудыг нэрлэн бичих]
ГЕН 10.21.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: [хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]
ГЕН 10.22.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: [хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо:	2024 оны 11 дүгээр сарын 28
Тендер шалгаруулалтын төрөл:	Үйлчилгээ
Тендер шалгаруулалтын нэр:	Улаанбаатар хотын "Шинэ их тойруу" хурдны зам төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар)
Тендер шалгаруулалтын дугаар:	ЗТХЯ/20240103134
Нийт төсөвт өртөг:	16,000,000,000 төгрөг, үүнээс 2024 онд 16,000,000,000 төгрөг санхүүжигдэнэ.
Тендер шалгаруулалтын арга:	Нэг үе шаттай нээлттэй тендер шалгаруулалт

1. Нийслэлийн Засаг даргын тамгын газар нь **Улаанбаатар хотын "Шинэ их тойруу" хурдны зам төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар) боловсруулах зөвлөх үйлчилгээ** үзүүлэх тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **"Үгүй"**
3. Тендерийг **2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 09 цаг 30 минутад** нээнэ.
4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **"Зөвшөөрөхгүй"**
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **"Эрхтэй"**
6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
7. Тендерийн баталгаа шаардах эсэх: **"Тийм"**
Тендерийн баталгааны дүн: 80,000,000 (наян сая) төгрөг
8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **"Үгүй"**
9. Тендер шалгаруулалтыг нэг үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **"Тийм"**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 23 дугаар хороо, Арцатын ам,
Нийслэлийн нутгийн захиргааны байр, Б-блок 7 дугаар давхар,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,
Утас: 75757810
www.tender.gov.mn